

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН VI АНГИ ДЭВШИХ  
ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР  
“А” ХУВИЛБАР**

Хугацаа: 60 минут

Нийт-20 оноо

Анги : Сурагчийн нэр :

**ЯНЗАГАТАЙ СОГОО**

Хөл дээрээ тэнцэж ядаж байгаа янзагандаа согоо хөхөө хөхүүлэв. Согоо янзагаа үнэрлэж салхины аясаар эвгүй үнэр ирэхийг мэдэрч, чоно ойрхон ирж явна гэж бодов. Гэлээ ч хөл дээрээ тэнцэн ядан байгаа янзагатай согоо хаашаа ч явах юм билээ. Чоно согоог барихад бэлэн болжээ. Чоныг харсан согоо бачимдавч янзагандаа хоргодоод хаашаа ч хөдөлсөнгүй зогсов. Согоо янзагаа өвчүүн дороо зогсоож өөрийн амиа золиосонд гаргахад бэлэн зогсоно. Чоно тэр лүү дайрах мөчид согоо янзагаа даран урд хоёр хөл дээрээ сөхрөн хэвтэхэд чоно согооны дээгүүр эрчиндээ харайж цаашаа эргэж ч харалгүй хурдлав.

**1. Доорх хэсгээс эхийн гол санаанд тохирох хэсгийг олж дугуйлаад тайлбарлан бичнэ үү? 2 оноо**

А. Эхийн санаа үрд

Үрийн санаа ууланд

Б. Үртэй хүн жаргадаг,

Үндэстэй мод ургадаг

В. Үхтэл үр харам

Г. Сэгсгэр ч гэсэн ээж минь

Сиймхий ч гэсэн гэр минь

**2. Эхийн санааг дүгнэсэн тулгуур өгүүлбэрийг олоод тайлбарлан бичнэ үү? 2 оноо**

А. Чоныг харсан согоо бачимдавч янзагандаа хоргодоод хаашаа ч хөдөлсөнгүй зогсов.

Б. Согоо өвчүүн дороо зогсоож өөрийн амиа золиосонд гаргахад бэлэн зогсоно.

В. Чоно тэр рүү дайрах мөчид согоо янзагаа даран урд хоёр хөл дээрээ сөхрөн хэвтэхэд чоно согооны дээгүүр эрчиндээ харайж цаашаа эргэж ч харалгүй хурдлав.

Г. Хөл дээрээ тэнцэж ядаж байгаа янзагандаа согоо хөхөө хөхүүлэв.

**3. Зөв байрлуулан дугаарыг бичнэ үү. 2 оноо**

1. Чоныг харсан согоо бачимдавч янзагандаа хоргодоод хаашаа ч хөдөлсөнгүй зогсов.

2. Чоно согоог барихад бэлэн болжээ.

3. Хөл дээрээ тэнцэж ядаж байгаа янзагандаа согоо хөхөө хөхүүлэв.

4. Согоо өвчүүн дороо зогсоож өөрийн амиа золиосонд гаргахад бэлэн зогсоно.

**4. Оноосон нэрийн доогуур нэг, ерийн нэрийг доогуур хоёр зураарай. 2 оноо**

Хэнтий, Хангай, Соёны өндөр сайхан нуруунууд

**5. Нэрийн тийн ялгалын нөхцөлийг бүгдийг нь зөв харгалзуулан дугаарыг бичээрэй. 2 оноо**

- |                            |                                   |
|----------------------------|-----------------------------------|
| 1. Өгөх оршихын тийн ялгал | А. Хөлийн, нутгийн, хорвоогийн    |
| 2. Хамтрахын тийн ялгал    | Б. Янзгандаа, золиосонд, эрчиндээ |
| 3. Харьяалахын тийн ялгал  | В. хөлтэй, чонотой, янзагатай,    |
| 4. Үйлдэхийн тийн ялгал    | Д. Хавраар, хөлөөр, хайраар       |

**6. “Алт, мөнгө хоёр” зохиолын агуулгыг бичнэ үү? 5 оноо**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

**7. Үндэсний бичгийн галигаас монгол бичигт хөрвүүлнэ үү? 5 оноо**

Хөхэ дэлэхэи эгүлэс-ийэр сайихан

Хөрөсүтү газар үндүсү-бэр сайихан

Хөл-үгэй далай усу-бар сай

--	--	--	--

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН VI АНГИ ДЭВШИХ  
ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР  
“Б” ХУВИЛБАР**

Хугацаа: 60 минут

Нийт-20 оноо

Анги : Сурагчийн нэр :

**ТАХИА БОЛСОН БҮРГЭД**

Бүргэдийн зулзага тохиолдлоор тахианы дэгдээхийнүүдийн дунд унажээ. Тэрээр тахиа шиг дуу гарч, идэх зүйл хайн гүйж, яг дэгдээхий мэт аашилдаг байв. Нэгэн өдөр тэнгэрт нисэн буй бүргэдийг олж: - Ямар гайхамшигтай шувуу вэ? Хэчнээн өндөрт нисэж байна вэ? Би энэ шувуу шиг нисэж чаддагсан бол түүн шиг халин дүүлэхсэн гэж өгүүлэхэд дэргэд нь байсан дэгдээхийнүүд: - Бид чинь тахиа шүү дээ. Битгий хоосон мөрөөдөөд бай. Тэр чинь бүргэд. Чи түүн шиг нисэж хэзээ ч чадахгүй гэгцгээв. Бүргэдийн зулзага маш их гуниглажээ. Хэн нэгэн түүнд бүргэд болохыг нь хэлж итгүүлэх хэрэгтэй байлаа. Гэвч хэн ч түүнд үнэнийг хэлээгүй тул амьдралынхаа төгсгөл хүртэл тахиа шиг амьдарчээ.

**1. Доорх хэсгээс эхийн гол санаанд тохирох хэсгийг олж дугуйлаад тайлбарлан бичнэ үү? 2 оноо**

- А. Хэрээ мэдэж бяраа тань                      Б. Биеэ мэдвэл хүн, Бэлчээрээ мэдвэл мал  
В. Хүн хэлээрээ мал хөлөөрөө

**2. Эхийн санааг дүгнэсэн тулгуур өгүүлбэрийг олж тайлбарлана уу? 2 оноо**

- А. Бид чинь тахиа шүү дээ.  
Б. Үнэнийг хэлээгүй тул амьдралынхаа төгсгөл хүртэл тахиа шиг амьдарчээ.  
В. Тэр чинь бүргэд                      Г. Маш их гуниглажээ.

**3. Үйл явдлын дарааллыг зөв байрлуулан бичнэ үү. 2 оноо**

- А. Тахианы дэгдээхийнүүдийн дунд унажээ.      Б. Бид чинь тахиа шүү дээ.  
В. Битгий хоосон мөрөөдөөд бай.                      Г. Хэчнээн өндөрт нисэж байна вэ?  
А. 1 2 3 4      Б. 2 3 1 4      В. 3 4 1 2      Г. 4 3 2 1      Д. 1 4 2 3

**4. Тийн ялгалын нөхцөлийг зөв залгасан хэсгийг олоорой. 2 оноо**

- А. Бүргэдийн, болохыг, үнэнийг, бүргэд      Б. Бүргэд, болох, амьдарчээ, зулзага  
В. Бүргэдийн, мөрөөдөөд, дунд, тахианы      Г. Амьдралынхаа, мөрөөдөөд, халин, бүргэдийг

**5. Цэгийн оронд тохирох тийн ялгалын нөхцөлийг зөв залгаж бичээрэй. 2 оноо**

...монгол нутаг... хангай газар дэлгэр зун... сайхан өдөр хонь... хариулна гэдэг юутай сайхан билээ.

6. "Шаргачин" өгүүллэгийн гол санааг өөрийн үгээр тайлбарлан бичээрэй. 5 оноо

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

7. Үндэсний бичгийн галигаас монгол бичигт хөрвүүлнэ үү? 5 оноо

салхиту тнгри-ийн эгүлэ нигэ хурдан

сарагул ухагтан-у санах-у нигэ хурдан

сайин морин-у дабхиу нигэ хурдан

| | | | | | | | | |